



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/402.

Мандалговь

Хариу арга хэмжээ авах ажлын
хэсгийг томилон, ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж" Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 1.12 дахь заалтууд, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/47 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 8-10 цаг үргэлжилсэн байгалийн онц аюултай үзэгдэл харанхуй шороон шуурганы улмаас үүссэн гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан хохирлын үнэлгээ тогтоох, эрсдэлийн үнэлгээ хийх, сэг зэм устгах ажлыг зохион байгуулах удирдлага, арга зүйгээр хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Л.Доржбат (Засаг даргын Тамгын газрын дарга)

Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Г.Энхтайван (Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Түвшинбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

М.Адъяабаатар (Онцгой байдлын газрын дарга)

Б.Мөнхжаргал (Хүнс хөдөө, аж ахуйн газрын дарга)

Б.Алтантөгс (Эрүүл мэндийн газрын дарга)

Г.Наранбаатар (Цагдаагийн газрын дарга)

Ш.Төрбат (Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Ш.Мөнхдүүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)


Я.Мажаасүрэн (Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)

Б.Энхтуяа (Статистикийн хэлтсийн дарга)

С.Гансүх (Цэргийн штабын дарга)

2. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох онц аюултай харанхуй шороон шуурганы улмаас аймгийн хэмжээнд үүссэн гамшгийн нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах ажлын төлөвлөгөөг яаралтай боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210293